



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ 2025

Тайлан хянасан:

М. Батгэрэл Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт,
судалгааны хүрээлэнгийн захирал

Н. Түмэн-Өлзий Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Ph.D)

Тайлан боловсруулсан:

Н. Жаргалсайхан Хөдөлмөрийн судалгааны секторын эрхлэгч

М. Ган-Эрдэнэ Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Тайлан зөвлөх:

Б. Алтанцэцэг Эн ар си си ХХК үндэсний судалгаа зөвлөгөөний төвийн
гүйцэтгэх захирал (Ph.D), дэд профессор

Б. Соёлмаа Ахлах судлаач (Ph.D), дэд профессор

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Б. Хос-Эрдэнэ Мэдээлэл технологийн албаны мэргэжилтэн

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам, 55-р байр 2 давхар 3 тоот
Утас: 77111331, 77121286 Вэб хуудас

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	6
ӨМНӨХ ҮГ	7
ХУРААНГУЙ	8
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
1.1 Үндэслэл	10
1.2 Зорилго, зорилт	11
1.3 Судалгааны хамрах хүрээ, түүврийн мэдээлэл.....	11
1.4 Судалгааны арга зүй, зохион байгуулалт	11
БҮЛЭГ 2. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	13
БҮЛЭГ 3. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ШИНЖ ЧАНАР	16
3.1 Судалгаанд хамрагдаагүй бүлгийн ерөнхий шинж чанар.....	17
3.2 Ерөнхий шинж чанар.....	19
БҮЛЭГ 4. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ	23
4.1 Процесс /сургалт/	23
4.2 Сэтгэл ханамж	27
БҮЛЭГ 5. ҮР ДҮН	30
5.1 Ажлын байр.....	30
5.2 Санхүүгийн байдал.....	35
5.3 Тулгарсан хүндрэл бэрхшээл.....	39
БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	42
6.1 Дүгнэлт	42
6.2 Зөвлөмж	43

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгаанд хамрагдаагүй бүлгийн насны бүлгээр /хувь/	17
Зураг 2. Судалгаанд хамрагдаагүй бүлгийн зээлийн зориулалт /хувь/	17
Зураг 3. Судалгаанд оролцогчдын хүйс, байршлаар /хувь/	19
Зураг 4. Насны бүлэг, байршлаар /хувь/	19
Зураг 5. Боловсролын түвшин, байршлаар /хувь/	20
Зураг 6. Зээлийн өмнөх сургалтад хамрагдсан байдал, байршлаар /хувь/	23
Зураг 7. Зээлийн өмнөх сургалтаар орсон мэдлэг мэдээллүүдийн сэтгэл ханамж /хувь/	23
Зураг 8. Төслийн давуу тал, байршлаар /хувь/	28
Зураг 9. Төслийн сул тал, байршлаар /хувь/	28
Зураг 10. Анхаарч ажиллах шаардлагатай санал /хувь/	29
Зураг 11. Зээл авсны дараа ажилтан нэмж авсан эсэх, байршлаар /хувь/	30
Зураг 12. Магадлалын маржинал нөлөө, ач холбогдол бүхий хувьсагчдын хувьд	33
Зураг 13. Бичил бизнесээ эрхэлж байгаа эсэх /хувь/	Error! Bookmark not defined.
Зураг 14. Гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран эрхэлдэг эсэх, байршлаар /хувь/	35
Зураг 15. Бизнесийн үйл ажиллагааны чиглэл /хувь/	36
Зураг 16. Бичил бизнес эрхлэгчдийн зээлийн зориулалт /хувь/	36
Зураг 17. Зээлийн шалгууртай холбоотой гарсан хүндрэл бэрхшээл, байршлаар /хувь/	39
Зураг 18. Арилжааны банкны зээлийн судалгаа чирэгдэлтэй байсан эсэх, байршлаар /хувь/	39
Зураг 19. Арилжааны банктай холбоотой тулгарсан асуудал, байршлаар /хувь/	40
Зураг 20. Эргэн төлөлттэй холбоотой асуудал үүссэн эсэх, байршлаар /хувь/	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын түүврийн хэмжээ, байршлаар	16
Хүснэгт 3. Регрессийн шинжилгээнд ашиглах хувьсагчид ба тэдний статистик үзүүлэлтүүд	21
Хүснэгт 4. Зээлийн дараах сургалтанд хамрагдсан эсэх /хувь/	24
Хүснэгт 5. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамж /хувь/	25
Хүснэгт 6. Төслийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамж /хувь/	27
Хүснэгт 7. Нэг ажил олгогчийн бий болгосон ажлын байр, байршлаар	Error! Bookmark not defined.
Хүснэгт 8. Ажилтан нэмж авсан бизнес эрхлэгчдийн тоо, байршлаар.....	30
Хүснэгт 9. Эмэгтэй ажилчдын тоо, байршлаар	31
Хүснэгт 10. Тайлбарлагч дамми хувьсагчид ажлын байр бий болгосон эсэхээр хэр ялгаатай байгааг харуулсан t тестүүд.....	31
Хүснэгт 11. Ажлын байр бий болгосон эсэхийг хамаарах хувьсагч болгон авч үзсэн логит үнэлгээний үр дүн.....	32
Хүснэгт 2. Бизнес эрхлэгчдийн бизнес эрхэлсэн хугацаа /жилээр/	35
Хүснэгт 12. Бичил бизнес эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдсэн байдал, байршлаар /хувь/	37
Хүснэгт 13. Тогтвортой байгаа эсэх /хувь/	37
Хүснэгт 14. Төсөлд хамрагдахын тулд бүрдүүлсэн баримт бичиг /хувь/	41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ББЭДХ – Бичил бизнес эрхлэгчдийн дэмжих хөтөлбөр

ХХҮЕГ – Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар

ГБХНХЯ- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ОБҮДХЭТ- Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл

ХЭДТ- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

ӨМНӨХ ҮГ

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр нь хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн суурь бүтцийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж буй бодлогын арга хэмжээ юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдэд зээл, сургалт, зөвлөгөө зэрэг санхүүгийн болон санхүүгийн бус цогц үйлчилгээ үзүүлснээр тэдний бизнесийн чадавх сайжирч, ажлын байр хадгалах болон шинээр бий болгох боломж нэмэгдэж байна.

2024 онд хөтөлбөрт хамрагдсан нийт бичил бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх зорилгоор энэхүү судалгааг зохион байгууллаа. Судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн нийт 379 бичил бизнес эрхлэгчийг хамруулснаар хөтөлбөрийн үйл явц, сургалтын үр нөлөө, зээлийн хүртээмж, зээл авснаас хойших бизнесийн өөрчлөлт, ажил эрхлэлтийн өсөлт зэрэг олон талт мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн юм.

Судалгааны үр дүн нь цаашдын бодлого боловсруулалт, хөтөлбөрийн сайжруулалт, бичил бизнес эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах гэдэгт итгэлтэй байна. Мөн энэхүү тайлан нь бичил бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад суурилсан, илүү оновчтой шийдвэрүүдийг гаргахад чиглэсэн судалгаанд суурилсан бодлогын нэгэн чухал эх сурвалцал болж байна.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, судалгаатай холбоотой асуудлаар санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье


ЗАХИРАЛ

М.БАТГЭРЭЛ

ХУРААНГУЙ

Судалгаанд нийт 21 аймаг 9 дүүргийн нийт бичил бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчдээс 379 буюу 64.6 хувийг судалгаанд хамруулсан. Үүнээс 195 бичил бизнес эрхлэгчдээс үйл ажиллагаа явуулж буй байршил дээр нь очиж танилцан урьдчилан боловсруулсан асуулгын дагуу судалгааг авсан. Үлдсэн бичил бизнес эрхлэгчдээс судалгааг утсаар авах ажлыг зохион байгуулж 184 бичил бизнес эрхлэгчийг судалгаанд хамруулсан.

Судалгаанд оролцогчдын хүйс, байршлаар /хувь/



Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн судалгаанд хамрагдагсдын 45.1% нь эрэгтэй, 47% нь дээд боловсролтой, 15.8% нь Улаанбаатар хотынх бөгөөд 35-аас 44 насныхан 33.5% байгаа нь бусад насны бүлгүүдтэй

харьцуулахад хамгийн өндөр хувь эзэлж байна. Бичил бизнес эрхлэгчдийн үндсэн хөрөнгө дунджаар 593.5 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 455.2 сая төгрөг бөгөөд тэдний 63.6% нь гэр бүлийн гишүүнтэйгээ хамтарч бизнес эрхэлдэг. Судалгаанд хамрагдсан иргэдийн 64.6% нь зээлийн өмнөх сургалтад бүрэн хамрагдсан.

Зээлийн өмнөх сургалтад хамрагдсан байдал /хувь/




Зээлийн дараах сургалт, үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн хувьд аж ахуй хөгжүүлэлт болон санхүүгийн бүртгэлийн сургалт нь сэтгэл ханамжтай буюу 50%-с дээш хувьтай

байгаа бол бусад үзүүлэлтийн хувьд дунд зэргийн сэтгэл ханамжтай байх нь дийлэнх хувийг эзэлж байсан. Үүнээс хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчин хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаарх зөвлөгөө өгөх байдалд бизнес эрхлэгчид нь дунд зэрэг болон түүнээс доош сэтгэл ханамжтай буюу 52.8%-н сэтгэл ханамжтай байна.

Бизнес эрхлэгчдийн 67.8% нь зээл олголтын процессын бүх үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай, 15.6% хувь нь маш их сэтгэл ханамжтай, 11.1% нь дунд зэрэг, үлдсэн 2.9% нь сэтгэл ханамжгүй болон огт сэтгэл ханамжгүй гэж үнэлжээ.


Зээл авсны дараа ажилтан нэмж авсан эсэх /хувь/



Судалгаанд оролцогчдын 50.9 хувь нь зээл авсны дараагаар ажилтан нэмж авсан бол 49.1 хувь нь ажилтан нэмж аваагүй байна. Судалгаанд хамрагдсан бичил бизнес эрхлэгчид нийт 1089 ажилтантай (зээл авахаас өмнөх ажилчдын тоо 661, нэмж авсан ажилчдын тоо 428) байна. Улаанбаатар хотын

хувьд нийт 35-н бичил бизнес эрхлэгч 76-н ажлын байрыг бий болгосон байгаа бол орон нутгийн хувьд 158-н бизнес эрхлэгч 352 ажлын байрыг бий болгосон байна.

Арилжааны банкны зээлийн судалгаа чирэгдэлтэй байсан эсэх



Арилжааны банктай холбоотой тулгарсан асуудлыг байршлаар харвал нийт судалгаанд оролцогчдын 32.2% нь “Барьцаа хөрөнгийн шаардлага өндөр”, 20.0% нь “Хугацаа их шаардсан” гэж үзэж байгаа бол 19.1% нь “Бүрдүүлэх материал их” гэж үзсэн байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэгчид “Бүрдүүлэх материал их”, орон нутгийн хувьд “Хугацаа их шаардсан” гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүндрэлтэй болон шаардлагагүй баримт бичиг байхгүй гэж үзсэн байна. Харин хүндрэлтэй бичиг баримт бичиг болон шаардлагагүй баримт бичгийн хувьд мөн барьцаа хөрөнгө орсон байна.

Төсөл хөтөлбөрт хамрагдагсдыг аж ахуй эрхлэлтийн болон бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамруулах, зээлийн хэмжээг нэмэгдүүлэх нь төслийн үр дүнд ажлын байр бий болох магадлалыг нэмэгдүүлэх боломжтой байна.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1.1 Үндэслэл

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) нь “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон техникийн дэмжлэгтэйгээр 2020-2025 онд хэрэгжүүлж байна. Төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил олгогч болон ажилтнуудад богино хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төсөл нь үндсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

- 1) Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх;
- 2) Төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх;
- 3) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- 4) Бизнес эрхлэгчид болон ажилтнуудад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд төслийн үр шим хүртэгчид болон хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн 2 судалгаа хийхээр төлөвлөж байна. Үнэлгээ хийгдэх арга хэмжээ болон үйлчилгээний төрлөөс хамаарч судалгааны байгууллага нь хоёр тусдаа сэтгэл ханамжийн судалгаа хийх шаардлагатай. Тухайлбал, төслийн бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд хэрэгжүүлэх “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” (ББЭДХ)-ийн үр шим хүртэгчид болон “И-Жоб” онлайн портал хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлно. Энэ хүрээнд дараах 2 төрлийн судалгааг гүйцэтгэнэ:

1. ББЭДХ-ийн бичил зээл, зээлийн өмнөх сургалт, зээлийн дараах үйлчилгээ хэлбэрээр дэмжлэг авсан бичил бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг үнэлэх, хөтөлбөрийн арга хэмжээний үр дүнг үнэлэх;
2. Цахим ажил зуучлалын “И-Жоб” порталыг ашигласан хэрэглэгчдийн туршлага, сэтгэл ханамжийн түвшнийг үнэлэх, ажил хайгчдад онлайн үйлчилгээ үзүүлэх давуу тал, сул тал болон сайжруулах чиглэлүүдийг тодорхойлох.

Иймд ГБХНХЯ бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэд болон “И-Жоб” онлайн ажил зуучлалын портал хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Судалгааны ажлын даалгавар нь ГБХНХЯ-нд техникийн дэмжлэг үзүүлэх зөвлөх байгууллагын гүйцэтгэх ажлын цар хүрээ, нийлүүлэх бүтээгдэхүүн, гүйцэтгэлийн үнэлгээ болон тайлагналтыг тодорхойлно.

1.2 Зорилго, зорилт

Судалгааны зорилго нь бичил бизнес эрхлэгчдийн дэмжлэг авсан иргэдийн сэтгэл ханамжийг үнэлж, хөтөлбөр, үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон цаашид хэрэгжүүлэхэд анхаарах санал, зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэж, ББЭДХ-ийн бичил зээл, зээлийн өмнөх сургалт, зээлийн дараах үйлчилгээ хэлбэрээр дэмждэг авсан бичил бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, хөтөлбөрийн арга хэмжээний үр дүнг үнэлэх.

Судалгааны үр дүнгээр дараах үзүүлэлтүүдийг тодорхойлно:

- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн байдал, хөтөлбөрийн арга хэмжээний үр дүн.
- Хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн зээл авснаас хойш 6 сарын дараах бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал.

1.3 Судалгааны хамрах хүрээ, түүврийн мэдээлэл

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан үр шим хүртэгчдээс авах судалгааны асуумжийг өмнөх шатны төслийн мөшгөх судалгааны асуумжид холбогдох өөрчлөлтийг хийж, шинэчлэн боловсруулна. Судалгаанд зээл авснаас хойш 6 сарын дараа үйл ажиллагаагаа явуулж байгаа бүх үр шим хүртэгчдийг хамруулна.

“Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-т 21 аймаг, 9 дүүргийн 587 гаруй бичил бизнес эрхлэгчдийг хамруулахаар төлөвлөж, тэдгээрийн 80.0-аас доошгүй хувийг буюу 467 бичил бизнес эрхлэгчийг судалгаанд хамруулахаар зорьж ажилласан. Үүнээс судалгааны баг 21 аймаг 9 дүүргийн бичил бизнесийн үйл ажиллагаа явуулж буй газар дээр нь очиж танилцан 195 бичил бизнес эрхлэгчдээс урьдчилан боловсруулсан асуулгын дагуу бэлтгэгдсэн судлаачид судалгааг авсан. Судлаач тухайн судалгаанд оролцогчоос батлагдсан асуулгын дагуу асуултуудыг нэг бүрчлэн асууж, таблет дээрх асуултыг бөглөх зарчмаар мэдээллийг цуглуулна. Үлдсэн бизнес эрхлэгчдээс судалгааг утсаар авах ажлыг зохион байгуулж 184 бичил бизнес эрхлэгчийг судалгаанд хамруулсан. Судалгаанд нийт 379 бичил бизнес эрхлэгч буюу оролцогчдын 64.6 хувийг судалгаанд хамруулсан.

1.4 Судалгааны арга зүй, зохион байгуулалт

2024 онд бичил бизнес эрхлэгчдийн дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн утасны дугаарын жагсаалт банкнаас дутуу ирсэн тул холбогдох аймаг, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсүүдтэй хамтран нийт бичил бизнес эрхлэгчдийн дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээллийг цуглуулсан ч зарим иргэдийн утасны дугаарын жагсаалт дутуу ирэх тохиолдол гарсан. Утсаар судалгааг зохион байгуулах ажлыг 7 сарын 31-нээс 8 сарын 7-ны өдрүүдэд зохион байгуулсан ба үлдсэн судалгаанд хамрагдаагүй иргэдтэй дахин 9 сарын 2-ноос 9 сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулсан холболтууд амжилтгүй болсон. Түүвэрт хамрагдсан нэг бичил бизнес эрхлэгчид рүү 5 удаагийн холболт хийсэн. Судалгааны ажлыг доорх ажлын хүрээнд гүйцэтгэсэн.

1. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд

- Судалгааны арга зүйг тодорхойлох, ажлын төлөвлөгөө график батлуулах;
- Судалгааны асуулга шинэчлэн, боловсруулж, турших;
- Судалгааны мэдээлэл цуглуулах баг сонгон шалгаруулах;

- Түүврийн аргачлалыг тодорхойлж, түүврийн зохиомжийг бэлтгэх;
- Түүврийг жагсаалт бэлэн болгох;
- Асуулгын хуудсыг эцэслэж бэлэн болгох.

2. Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдэд судалгааны талаар зааварчилгаа мэдээллийг өгч мэдээлэл цуглуулалтын багийг бүрдүүлэх.
- Бэлэн болсон судалгааны асуумжаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдтэй хамтран хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл цуглуулна.
- Мэдээлэл цуглуулалтын Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдтэй хамтран бичил бизнес эрхлэгчдийн байршил дээр очин судалгааг авч хамтран ажиллах.
- Судалгааны асуумжаар үндсэн баг утсаар мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах.

3. Боловсруулалт хийх ажлын хүрээнд

Судалгааны мэдээллийг анализ хийх зориулалтын программд шивж оруулах, үр дүнг боловсруулж, шинжилгээ хийхэд STATA, R программ хангамжийг ашиглана. Мэдээлэл цуглуулж буй аргаас хамаарч мэдээллийг нэгтгэхэд өөр төрлийн программ хангамж ашиглаж болно. Дараах ажлууд хийж гүйцэтгэсэн байна.

- Мэдээллийн санд хяналтын ажлыг хийх;
- Мэдээллийн тойм бэлдэх /outline/;
- Үр дүнгийн хүснэгт, график бэлтгэх;
- Судалгааны үр дүнгийн тайланг бэлэн болгох.

БҮЛЭГ 2. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

“Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /ГБХНХЯ/ хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийг 2020 оны 6-р сарын 19-ний өдөр баталсан бөгөөд 2020 оны 11-р сарын 9-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. ОБҮДХЭТ нь ГБХНХЯ-аас хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн үргэлжлэл юм.

Уг төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлд хөнгөлөлт, санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг үзүүлэх замаар бичил бизнес эрхлэгчдэд цогц дэмжлэг үзүүлэх зорилготой. Одоогоор бичил бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа болон шинээр бизнесээ эхлүүлж буй хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт зориулан жижиг зээл олгох, жижиг зээлд хамрагдахаар хүсэлт гаргагч болон үр шим хүртэгчдэд зээл авахаас өмнө болон зээл авсны дараа санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх (бизнесийн ур чадварыг хөгжүүлэх сургалт болон менторын үйл ажиллагаа)-г хэрэгжүүлнэ.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт (Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг) хэрэгжинэ. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа нь үндсэндээ төв, суурин газрын оршин суугчдад чиглэнэ.

Төсөл нь хоёр төрлийн үр шим хүртэгчтэй байна. Төслийн эхний үр шим хүртэгч нь төслийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн холбогдох үйлчилгээ, дэмжлэгт хамрагдах хүн амын эмзэг бүлгийн ажил хайгч иргэн болон бичил бизнес эрхлэгч байна. Ерөнхийдөө Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан “ажил хайгч” буюу ажилгүй, ажилтай боловч шинэ ажил хайж байгаа иргэн, “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” буюу 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн хамрагдана.

Зээлийн эрсдэл өндөр, эрсдэлтэй эмзэг бүлгийн иргэдийг зээлд хамруулахдаа өргөдөл гаргагчийн бизнесийн туршлага болон тодорхой бизнесийн оновчтой төлөвлөгөө, аж ахуйн нэгжийн амжилтад хүрэх магадлал, эмзэг байдал зэргийг харгалзан 3-5 сая төгрөгийн зээлийг олгоно.

Жижиг зээлийг бичил бизнес эрхлэгч нарт олгохтой холбоотой тухайн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх зарим нийгмийн эрсдэл үүсэж болох бөгөөд үүнийг холбогдох хяналт болон сонгон шалгаруулалтын шалгуураар шийдэх боломжтой юм.

ББЭДХ-ийн хүрээнд олгож буй жижиг зээлийн үр шим хүртэгчдийн 50-иас доошгүй хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчид байх нөхцөлийг бүрдүүлнэ. Төсөл нь байгаль орчинд ихээхэн хэмжээний эрсдэл учруулах бичил үйлдвэрүүдийг санхүүжүүлэхгүй.

Бичил үйлдвэрүүдийн хэв шинж нь дараах байдалтай байхаар төлөвлөж байна. Үүнд: хүнсний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ (үсчин, цэвэрлэгээ, гутал засвар, цаг засвар, цахилгаан хэрэгслийн засвар); боловсруулах болон бусад үйлдвэрлэл (оёдол, сүлжмэл, нэхмэл, арьс ширэн эдлэл, мужаан, төмөр эдлэл,

барилгын материалын үйлдвэрлэл); хөдөө аж ахуй, газар тариалан, сүү, цагаан идээ боловсруулах; авто засвар, авто угаалга, сэлбэгийн худалдаа.

Бичил бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг (ихэвчлэн бичил зээл хэлбэрээр) болон төрөл бүрийн санхүүгийн бус үйлчилгээг үзүүлнэ. Бичил зээлийн хэмжээ 1,750-3500 ам.долларын хооронд байх бөгөөд зээлийн хугацаа 24 сар хүртэл байна. Жижиг зээлийг хөдөлмөрийн зах зээл дээрх хүндрэл, бэрхшээлтэй илүү их тулгарч байгаа одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр үйл ажиллагаа эхэлж буй бичил бизнес эрхлэгчдэд олгоно. Нөгөөтээгүүр төсөл нь ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, ялангуяа өсөн нэмэгдэж буй бүтээмжтэй бичил бизнесийн салбарыг хөгжүүлэхэд тулгарч буй хөдөлмөрийн зах зээлийн хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх болно. Жижиг зээлийн хүрээнд тухайн бичил бизнес эрхлэгч шаардлагатай байгаа тоног төхөөрөмж болон бараа материал, түүхий эд худалдан авах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл нь ХЭДТ-ийн хүрээнд авч үзсэн үр шим хүртэгчдийн үйл ажиллагааны чиглэлтэй төстэй байх болно.

ХЭДТ-ийн үр шим хүртэгчдийн 39% нь хүнсний үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч, 22% нь үйлчилгээ (үсчин, цэвэрлэгээ, гутал, цаг, цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ), 19% нь боловсруулах болон бусад үйлдвэрлэл (оёдол, сүлжмэл, нэхмэл, арьс ширэн эдлэл, мужаан, төмөр хийц, барилгын материалын үйлдвэрлэл), 11% нь хөдөө аж ахуй, газар тариалан, сүү, цагаан идээ боловсруулах, 9% нь авто засвар, авто угаалга, сэлбэг хэрэгслийн худалдаа эрхлэгч байсан.

Төсөл нь байгаль орчин болон нийгэмд их хэмжээний эрсдэл учруулахуйц бичил үйлдвэрүүдийг санхүүжүүлэхгүй тул төслийн хүрээнд байгаль орчин болон нийгэмд ямар нэгэн мэдэгдэхүйц болон эргэлт буцалтгүй, их хэмжээний нөлөө үзүүлэх магадлал бага байна. Санхүүжүүлэх үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн үр дагаврын хувьд бага буюу дунд зэргийн эрсдэлтэй байх болно. Эцсийн байдлаар бичил бизнес эрхлэгчдэд зээл олгох ажлыг сонгогдсон санхүүгийн байгууллага гүйцэтгэх бөгөөд төслийн хүрээнд дэмжлэг авах бичил бизнес эрхлэгчдийн байгаль орчны асуудлыг анхааран үзэх болно.

Сонгон шалгаруулалт хийхдээ төслийн хүрээнд санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг ашиглах бөгөөд зөвхөн дунд болон бага эрсдэлтэй бичил бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс (ХХҮХ) нь хариуцсан албан тушаалтнаар дамжуулан зээлийн өмнөх сургалтад хамрагдах хүсэлтэй бичил бизнес эрхлэгчдийг бүртгэх бөгөөд үүний дараа бичил зээлийн санал хүлээж авах ажлыг хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан ББЭДХ нь бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх болон санхүүгийн бус чадавхыг дээшлүүлэх замаар ажлын байр хадгалах, шинээр бий болгох, улмаар зорилтот хүн амын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Хөтөлбөрийн хүрээнд 550-аас доошгүй бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгохоор төлөвлөж байна. Жижиг зээл авсан бүх зээлдэгчдийг бичил бизнес эрхлэгчдийг дэмжих цогц арга хэмжээнд хамруулна.

Хөтөлбөр нь дараах 3 төрлийн арга хэмжээнээс бүрдэнэ:

- а) Зээл хүсэгчдийн бизнесийн санааг хөгжүүлэх, бизнес төлөвлөлт, төсөл бичих ур чадварыг сайжруулахад чиглэсэн зээлийн өмнөх сургалт;
- б) Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих бичил зээлийн хэлбэрээр олгох санхүүгийн дэмжлэг;
- с) Зээлийн дараах олон төрлийн санхүүгийн бус үйлчилгээ, үүнд бизнесийн ур чадвар, хөгжлийн 20 цагийн сургалт, үр шим хүртэгчдийн хэрэгцээнд тулгуурлан уян хатан нөхцөлөөр үзүүлэх 10 цагийн зөвлөн туслах үйлчилгээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулах, үр дүнг хянах, тайлагнах ажлыг хариуцаж ажиллана. ХХҮЕГ, аймаг, дүүргийн хэлтсүүд зээлийн өмнөх сургалт болон зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний хэрэгжилтийг анхан шатанд хариуцаж ажиллана. Хөтөлбөрийн жижиг зээл олгох арга хэмжээг хамтрагч санхүүгийн байгууллагуудаар дамжуулан гэрээгээр гүйцэтгүүлнэ. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан. Удирдамжид хөтөлбөрийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууллагын болон зохион байгуулалтын зохицуулалтыг дэлгэрэнгүй тодорхойлсон.

БҮЛЭГ 3. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ШИНЖ ЧАНАР

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийг байршил буюу аймаг, дүүрэг харьяаллаар харвал нийт түүврийн 84.2 хувь нь орон нутгаас үлдсэн хувь нь УБ хотоос хамрагдсан байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын түүврийн хэмжээ, байршлаар

	Аймаг	Судалгаанд хамрагдсан	Судалгаанд хамрагдаагүй	Нийт
1	Дорнод	11	9	20
2	Сүхбаатар	10	18	28
3	Хэнтий	16	3	19
4	Төв	11	4	15
5	Говь-Сүмбэр	6	7	13
6	Сэлэнгэ	7	7	14
7	Дорноговь	6	4	10
8	Дархан-Уул	38	12	50
9	Өмнөговь	9	5	14
10	Дундговь	7	2	9
11	Орхон	6	1	7
12	Өвөрхангай	20	6	26
13	Булган	6	5	11
14	Баянхонгор	17	2	19
15	Архангай	32	16	48
16	Хөвсгөл	4	9	13
17	Завхан	11	0	11
18	Говь-Алтай	26	6	32
19	Баян-Өлгий	8	5	13
20	Ховд	32	0	32
21	Увс	36	34	70
Нийт		319	155	587
Улаанбаатар /дүүрэг/				
1	Багануур	5	10	15
2	Баянгол	21	17	38
3	Багахангай	0	0	0
4	Баянзүрх	7	4	11
5	Налайх	4	0	4
6	Сонгинохайрхан	13	0	13
7	Сүхбаатар	1	22	23
8	Хан-Уул	5	0	5
9	Чингэлтэй	4	0	4
Нийт		60	53	113
Нийт		379	208	587


3.1 Судалгаанд хамрагдаагүй бүлгийн ерөнхий шинж чанар

“Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-т 2024 оны байдлаар нийт 587 бичил бизнес эрхлэгчдийг түүвэрлэн хандсан боловч судалгаанд 379 бичил бизнес эрхлэгч хамрагдаж 208 бичил бизнес эрхлэгч судалгаанд хамрагдаагүй байна. Хамрагдаагүй бүлгийг байршлаар авч үзвэл 74.5% нь орон нутаг, 25.5% нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа эрхэлдэг байна.

Утсаар судалгааг зохион байгуулах ажлыг 7 сарын 31-нээс 8 сарын 7-ны өдрүүдэд гүйцэтгэсэн ба үлдсэн судалгаанд хамрагдаагүй иргэдтэй дахин 9 сарын 2-ноос 9 сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулсан холболтууд амжилтгүй болсон. Судалгаанд оролцох нэг бичил бизнес эрхлэгчтэй 5 удаагийн холболт хийсэн.

Судалгаанд хамрагдаагүй бүлгүүд нь холбогдох утасны дугаар байхгүй, холбогдох боломжгүй, дугаар ашиглалтад байхгүй, дугаар андуурсан, судалгаанд хамрагдахаас татгалзсан болон зээл авснаа санахгүй байна зэрэг шалтгаануудын улмаас судалгаанд оролцоогүй болно.

Зураг 1. Судалгаанд хамрагдаагүй бүлгийн насны бүлгээр /хувь/



Судалгаанд хамрагдаагүй бүлгийг насны бүлэг, хүйсээр дээр зурагт харуулсан бөгөөд 36-45 насны иргэд хамгийн өндөр хувийг буюу 31.4 хувийг эзэлж байгаа бол хүйсийн хувьд 57.7% нь эмэгтэй 42.3% нь эмэгтэй байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдаагүй бүлгийн зээлийн зориулалт /хувь/




Судалгаанд хамрагдаагүй бүлгийн зээл авч буй зориулалтын хувьд эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зориулалтаар зээл авах нь 25.4 хувийг эзэлж байгаа бол бизнестээ хөрөнгө оруулах буюу тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар зээл авсан бизнес эрхлэгчид нь 25.4 хувийг, үйл ажиллагааг өргөжүүлэх болон бараа материал түүхий эдийг нэмэгдүүлэх зориулалтаар зээл авч буй бизнес эрхлэгчид тус тус 15.6 хувийг эзэлж байна.

3.2 Ерөнхий шинж чанар


Судалгаанд нийт 21 аймаг 9 дүүргийн бичил бизнесийн үйл ажиллагаа явуулж буй 195 оролцогчдын байршил дээр нь очиж танилцан урьдчилан боловсруулсан асуулгын дагуу судалгааг авсан. Үлдсэн 184 бичил бизнес эрхлэгчдээс судалгааг утсаар авах ажлыг зохион байгуулж нийт 379 бичил бизнес эрхлэгч буюу 64.6 хувийг судалгаанд хамруулсан.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын хүйс, байршлаар /хувь/




Нийт судалгаанд оролцогчдыг хүйсээр харвал харьцаа ойролцоо буюу тэнцвэртэй байна. Харин байршлаар харахад Улаанбаатарт бичил бизнес эрхэлдэг иргэдийн 68.3% нь хувь нь эмэгтэй байна.

Зураг 4. Насны бүлэг, байршлаар /хувь/



Судалгаанд хамрагдсан бичил бизнес эрхлэгчдийн насны бүлгээр харвал 36-45 насны иргэд хамгийн өндөр хувийг эзлэх бөгөөд байршлаар харвал Улаанбаатар хотын хувьд мөн 36-45 насны иргэд хамгийн өндөр 40%-ийг эзэлж байна.

Зураг 5. Боловсролын түвшин, байршлаар /хувь/



Бичил бизнес эрхлэгчдийг нийт түүврийн хувьд авч үзвэл 47.0% нь дээд боловсролтой, 27.7% нь бүрэн дунд боловсролтой, 12.1% нь тусгай дунд боловсролтой байна. Харин байршлын ялгаагаар харвал Улаанбаатар хотын хувьд хамгийн өндөр буюу 61.7% нь дээд боловсролтой байгаа бол орон нутгийн хувьд мөн ялгаагүй 44.2% нь дээд боловсролтой байна.

Регрессийн шинжилгээ

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн асуумж судалгааны мэдээлэлд үндэслэн тус төслийн хүрээнд ажлын байр бий болох нь төсөл, хөтөлбөрт хамрагдагсдын нас, боловсрол болон байршил зэрэг нийгэм, эдийн засгийн шинж чанар, эрхэлдэг бизнесийн үзүүлэлтүүд болон төслийн хүрээнд зээлээс бусад сургалт, зөвлөгөөний үйлчилгээ авсан зэрэг үзүүлэлтүүдтэй ямар хамааралтай байгаад шинжилгээ хийлээ. Уг шинжилгээнд ажлын байр нэмэгдүүлсэн эсэх гэдэгт хариулсан байдлыг хамааран хувьсагч болгон авч үзсэн. Төслөө хэрэгжүүлснээр ажилтан нэмж авсан уу гэдэг асуултад нийт судалгаанд хамрагдагсдын 51% нь тийм гэсэн хариулт өгчээ (**Хүснэгт 2**).

Бид тэгшитгэл (1)-ын логик загварыг үнэлснээр төслийн хүрээнд ажлын байр бий болох магадлал ба бусад тайлбарлагч хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээг хийх боломжтой.

$$\text{logit}(P(Y = 1)) = \ln \left(\frac{P(Y=1)}{1-P(Y=1)} \right) = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_k X_k \quad (1)$$

$P(Y = 1)$ нь ажлын байр бий болох магадлал, $\beta_0, \beta_1, \beta_2, \dots, \beta_k$ нь тайлбарлагч хувьсагчдын өмнөх коэффициентууд. $X_1, X_2, \dots, X_k$ нь тайлбарлагч хувьсагчид бөгөөд шинжилгээнд

ашиглах тайлбарлагч хувьсагчид болон тэдгээрийн статистик үзүүлэлтүүдийг **Хүснэгт 2-т** харуулсан.

Хүснэгт 2. Регрессийн шинжилгээнд ашиглах хувьсагчид ба тэдний статистик үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Ажиглал тын тоо	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн бага утга	Хамгийн их утга
Ажлын байр нэмэгдүүлсэн	379	0.509	0.501	0	1
Бизнесийн үзүүлэлтүүд					
Үндсэн хөрөнгө, сая.төг	349	593.563	4212.764	1	50000
Эргэлтийн хөрөнгө, сая.төг	378	455.195	5155.719	1	90000
Бизнесийг гэр бүлийн гишүүнтэй хамтран эрхэлдэг	379	0.636	0.482	0	1
Сургалт, зөвлөгөө					
Санхүүгийн үйлчилгээнд хамрагдсан	379	0.570	0.496	0	1
Зээлийн өмнөх сургалтад бүрэн хамрагдсан	379	0.646	0.479	0	1
Аж ахуй хөгжүүлэлтийн сургалтад хамрагдсан	379	0.253	0.435	0	1
Санхүүгийн бүртгэлийн сургалтад хамрагдсан	379	0.412	0.493	0	1
Маркетинг, борлуулалтын чиглэлийн сургалтад хамрагдсан	379	0.430	0.496	0	1
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалтын үйлчилгээ авсан	379	0.438	0.497	0	1
Бизнес, менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг авсан	379	0.435	0.496	0	1
Менторинг үйлчилгээ авсан	379	0.338	0.474	0	1
ХАБ, байгаль орчин, эрүүл мэндийн зөвлөгөө авсан	379	0.367	0.483	0	1
Нийгэм, эдийн засгийн шинж чанар					
Эрэгтэй	379	0.451	0.498	0	1
Дээд боловсролтой	379	0.470	0.500	0	1
Улаанбаатарт амьдардаг	379	0.158	0.366	0	1
24 хүртэлх насны	379	0.042	0.201	0	1
25-34 насны	379	0.187	0.391	0	1
35-44 насны	379	0.335	0.473	0	1
45-54 насны	379	0.251	0.434	0	1
55-аас дээш насны	379	0.185	0.389	0	1

Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгөөс бусад тайлбарлагч хувьсагчид нь тэг ба нэг гэсэн утга авдаг дамми хувьсагчид болно.

Бичил бизнес эрхлэгчдээс дэмжих хөтөлбөрийн судалгаанд хамрагдагсдын 45.1% нь эрэгтэй, 47% нь дээд боловсролтой, 15.8% нь Улаанбаатар хотынх бөгөөд 35-аас 44 насныхан 33.5% байгаа нь бусад насны бүлгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр хувь эзэлж байна. Бичил бизнес эрхлэгчдийн үндсэн хөрөнгө дунджаар 593.5 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 455.2 сая төгрөг бөгөөд тэдний 63.6% нь гэр бүлийн гишүүнтэйгээ хамтарч бизнесээ эрхэлдэг. Судалгаанд хамрагдсан иргэдийн 64.6% нь зээлийн өмнөх сургалтад бүрэн хамрагдсан.


БҮЛЭГ 4. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Энэ бүлэгт бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн сэтгэл ханамж болон хөтөлбөрт хамрагдах процессын сэтгэл ханамжийн мэдээллийг хүргэнэ.

4.1 Процесс /сургалт/

Бичил бизнес эрхлэгчдийн зээлийн өмнөх сургалтын үйл ажиллагаанд өгч буй сэтгэл ханамжийн түвшнийг 3 дэд бүлгийн 13 нэгж үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн ба үнэлгээг арга зүйд тусгасны дагуу 1-5 онооны шатлал бүхий “Сэтгэл ханамжийн индекс”-ээр тодорхойлсон.


Зураг 6. Зээлийн өмнөх сургалтад хамрагдсан байдал, байршлаар /хувь/



Судалгаанд оролцогчдыг зээл авахын өмнөх сургалтад хамрагдсан байдлаар байршлаар харьцуулан үзэхэд Улаанбаатар хотод бизнес эрхлэгчдийн 55% нь сургалтад хамрагдсан бол орон нутагт бизнес эрхлэгчдийн 66.5% нь зээлийн өмнөх сургалтад хамрагдсан байна. Үүнээс

харахад зээлийн өмнөх сургалтад хамрагдсан байдал орон нутагт бизнес эрхлэгчид илүү өндөр хувьтай байгаа юм.

Зураг 7. Зээлийн өмнөх сургалтаар орсон мэдлэг мэдээллүүдийн сэтгэл ханамж /хувь/



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь зээлийн өмнөх сургалтаар орсон мэдлэг мэдээллүүдэд дунд зэрэг түүнээс дээш сэтгэл ханамжтай байна. Тухайлбал, бизнесийн төсөл боловсруулах, зээл авахад бүрдүүлэх баримт бичиг болон зээлийн хүүгийн хөнгөлөлтийн талаарх мэдээллүүдэд судалгаанд оролцогчид нь 57% -аас 66% нь сэтгэл ханамжтай буюу дунд зэрэг сэтгэл ханамжтай байгаа бол зээл авахад тавигдах шаардлага болон бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс

хамгаалах урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлд сэтгэл ханамжтай байх нь бусад үзүүлэлтүүдээс хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм.

Хүснэгт 3. Зээлийн дараах сургалтад хамрагдсан эсэх /хувь/

	Зээлийн дараах сургалт	Тийм	Үгүй
Зээлийн дараах сургалт	Аж ахуй хөгжүүлэлтийн сургалт	25.3	74.7
	Санхүүгийн бүртгэлийн сургалт	41.2	58.8
	Маркетинг, борлуулалтын чиглэлийн сургалт	43.0	57.0
Үйлчилгээнүүд	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалтын үйлчилгээ	43.8	56.2
	Бизнес, менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ	43.5	56.5
	Менторинг үйлчилгээ	33.8	66.2
Зөвлөгөө	Төслийн хэрэгжилтэд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаар	36.7	63.3

Судалгаанд оролцогчдын зээл авсны дараах сургалтад хамрагдсан байдлыг авч үзэхэд дийлэнх үзүүлэлтүүд “үгүй” гэх хариулттай буюу зээлийг авсны дараах сургалтад хамрагдахгүй байх хандлагатай байгаа тул зээлийн дараах сургалтад хамрагдах байдалд анхаарах шаардлагатай хэмээн үзэж байна.

Хүснэгт 4. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамж /хувь/

	Маш их сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд зэрэг	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
Зээлийн дараах сургалт, үйлчилгээтэй холбоотой						
Аж ахуй хөгжүүлэлтийн сургалт	1.9	0.9	7.4	54.6	22.2	13.0
Санхүүгийн бүртгэлийн сургалт	1.9	0.9	6.5	49.1	25.0	16.7
Маркетинг, борлуулалтын чиглэлийн сургалт	1.9	8.3	50.9	23.1	15.7	0.0
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалтын үйлчилгээ	1.9	7.4	49.1	23.1	18.5	0.0
Бизнес, менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ	1.9	9.3	52.8	21.3	14.8	0.0
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчин хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаарх зөвлөгөө өгөх байдал	3.7	13.0	36.1	25.0	22.2	0.0
Сургалтын зохион байгуулалттай холбоотой						
Сургалт үргэлжлэх хугацаа	0.9	19.4	50.0	23.1	6.5	0.0
Сургалтын танхимын хүрэлцээтэй байдал	0.9	1.9	11.1	54.6	25.0	6.5
Шаардлагатай тоног төхөөрөмжөө хангасан байдал	1.9	2.8	12.0	51.9	24.1	7.4
Зохион байгуулалтын багийн харилцаа, хандлага	0.9	4.6	56.5	31.5	6.5	0.0
Санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбоотой үзүүлэлтүүд						
Сургалттай холбоотой мэдээ, мэдээлэл хүргэлт	0.9	0.9	7.4	54.6	28.7	7.4
Сургалт хариуцсан багшийн ур чадвар	0.9	6.5	51.9	34.3	6.5	0.0
Сургалт хариуцсан багшийн харилцаа, хандлага	0.9	0.9	2.8	58.3	30.6	6.5
Мэдлэг, мэдээллээ ойлгомжтой хүргэх байдал	0.9	0.9	4.6	53.7	33.3	6.5
Бичил бизнес эрхлэгчдэд хүрч ажиллах байдал	0.9	0.9	6.5	53.7	30.6	7.4
Бичил бизнес эрхлэгчдийн хэрэгцээг хангаж ажиллах байдал	0.9	0.9	8.3	50.0	30.6	9.3

Зээлийн дараах сургалт, үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн хувьд аж ахуй хөгжүүлэлт болон санхүүгийн бүртгэлийн сургалт нь сэтгэл ханамжтай буюу 50%-с дээш хувьтай байгаа бол бусад үзүүлэлтийн хувьд дунд зэргийн сэтгэл ханамжтай байгааг дээрх хүснэгтээс харагдаж байна. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчин хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаарх зөвлөгөө өгөх байдалд бизнес эрхлэгчдийн 52.8%-н дунд зэрэг болон түүнээс доош сэтгэл ханамжтай байна.

Харин сургалтын зохион байгуулалттай холбоотой оролцогчдын сэтгэл ханамжийн хувьд дунд зэрэг болон түүнээс дээш сэтгэл ханамжтай байх нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм. Санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай холбоотой үзүүлэлтүүдэд оролцогчдын 50 болон түүнээс дээш хувь нь сэтгэл ханамжтай байгаа нь энэхүү үзүүлэлтэд хамаарах үйлчилгээнүүд нь хангалттай буюу сайн үнэлэмжтэй байна.

4.2 Сэтгэл ханамж


Бизнес эрхлэгчдийн 67.8% нь зээл олголтын процессын бүх үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай, 15.6% хувь нь маш их сэтгэл ханамжтай, 11.1% нь дунд зэрэг, үлдсэн 2.9% нь сэтгэл ханамжгүй болон огт сэтгэл ханамжгүй гэж үнэлжээ.

Хүснэгт 5. Төслийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамж /хувь/

	Маш их сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд зэрэг	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
Төслийн мэдээлэл хүргэх үйл ажиллагаа	1.3	4.7	10.0	67.6	15.3	1.1
Төслийн багийн харилцаа хандлага	1.6	1.8	3.7	71.3	21.3	0.3
Төслийн багийн санал гомдол хүлээн авах байдал	0.8	2.9	7.1	52.4	9.7	27.1
Төслийн багийн төсөл шалгаруулах байдал	1.1	1.6	5.8	70.8	19.2	1.6
Зээлийн өмнөх сургалт	0.8	1.1	3.4	47.6	20.5	26.6
Зээл олгох процесс	0.8	2.9	11.1	67.8	15.6	1.8
Зээлийн дараах сургалт	0.8	1.1	5.0	42.7	13.2	37.2
Зээлийн дараах үйлчилгээ	1.1	2.1	6.9	58.8	10.0	21.1


Төслийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлтүүдэд судалгаанд оролцогчдын дийлэнх сэтгэл ханамжтай байх хандлагатай байна. Гэвч дээрх үзүүлэлтүүдээс зээлийн дараах сургалтад оролцогчдын хариулт нь хэлж мэдэхгүй гэх хариулт мөн өндөр хувь буюу 37.2% байгаагаас үзэхэд зээлийн дараах сургалтад анхаарах шаардлагатай юм.

Зураг 8. Төслийн давуу тал, байршлаар /хувь/



Төслийн давуу талыг бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан нийт иргэдийн хувьд 25.8% нь “Бусад” гэсэн хариултыг өгсөн бөгөөд бүгд “зээлийн хүү бага” гэсэн хариултыг өгсөн байна. Дараагийн өндөр хувийг эзэлж байгаа үзүүлэлт бол 23.1% нь “Эргэлтийн хөрөнгөтэй болох”, 20.1% нь “Бичил бизнесийн үйл ажиллагааг тогтворжуулах” гэж харжээ. Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид төслийн давуу талыг бусад буюу зээлийн хүү бага гэж үзсэн байгаа бол орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд “Эргэлтийн хөрөнгөтэй болох” гэж харсан байна.

Зураг 9. Төслийн сул тал, байршлаар /хувь/



Нийт судалгаанд оролцогчдын 35.7% нь “Зээлийн хэмжээ бага” байгаа нь төслийн сул тал, харин 27.5% нь “Бусад” гэсэн сонголтыг хийсэн байгаа нь өндөр хувийг бүрдүүлж байна. Мөн оролцогчдод “Зээлийн шалгуур өндөр” байгаа болон “Олон шат дамжлагатай” байгааг төслийн хувьд сул тал гэж үзэж байна.

Зураг 10. Анхаарч ажиллах шаардлагатай санал /хувь/



Судалгаанд хамрагдсан оролцогчдоос “Төслийг дахин санал болговол” юун дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг тодруулахад 36.7% нь “Зээлийн хэмжээг нэмэгдүүлэх”, 21.5% нь “Зээлийн нөхцөлийг уян хатан болгох”, 11.5% нь “Төсөл хэрэгжүүлэх нэгж болон банкнууд уялдаа, хамааралтай ажиллах” гэсэн сонголтуудыг хийсэн байна. Дээр дурдсанчлан судалгаанд оролцогчид төслийн сул талыг “зээлийн хэмжээ бага” гэсэн байгаа нь энд мөн дурдаж байгаа нь харагдаж байна.


БҮЛЭГ 5. ҮР ДҮН

Нийт судалгаанд оролцогчдын 98.7% нь зээл авсан бизнесээ одоо эрхэлсээр байгаа бол 1.3 хувь нь өөр чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлж байна.

5.1 Ажлын байр

Зээл авсны дараагаар ажилтан нэмж авсан бизнес эрхлэгчид дунджаар 2.2 ажлын байр, хамгийн ихдээ 12, хамгийн багадаа 1 ажлын байр бий болгон ажилтан авчээ. Бизнес эрхлэгчид нийт 428 хүнийг ажлын байраар хангаж, ажилтан авсан байна. Харин орон нутгийн бизнес эрхлэгчид нийт 352 ажлын байранд, хотын бизнес эрхлэгчид нийт 76 ажлын байр бий болгон ажилтан авчээ.

Зураг 11. Зээл авсны дараа ажилтан нэмж авсан эсэх, байршлаар /хувь/



Зээл авсны дараагаар судалгаанд оролцогчдын 50.9 хувь нь ажлын байр бий болгосон бол 49.1 хувь нь ажлын байр нэмж бий болгоогүй байна. Байршлын хувьд орон нутаг болон хотод төдийлөн ялгаагүй үр дүнтэй ижил байна.

Улаанбаатар хотод нийт 35 бизнес эрхлэгч 10 хүртэлх ажлын байрыг бий болгожээ. Харин орон нутагт нийт 158 бизнес эрхлэгч 12 хүртэлх ажилтан нэмж авсан буюу шинэ ажлын байрыг бий болгосон байна.

Хүснэгт 6. Ажилтан нэмж авсан бизнес эрхлэгчдийн тоо, байршлаар

№	Ажилтны тоо	Улаанбаатар		Орон нутаг		Нийт	
		Давтамж	Эзлэх хувь	Давтамж	Эзлэх хувь	Давтамж	Эзлэх хувь
1	1	16	45.7	61	38.6	77	39.9
2	2	8	22.9	59	37.3	67	34.7
3	3	7	20.0	13	8.2	20	10.4
4	4	2	5.7	11	7.0	13	6.7
5	5	1	2.9	10	6.3	11	5.7
6	7	0	0.0	1	0.6	1	0.5
7	9	0	0.0	1	0.6	1	0.5
8	10	1	2.9	0	0.0	1	0.5
9	12	0	0.0	2	1.3	2	1.0
Нийт		35	100.0	158	100.0	193	100.0

Судалгаанд хамрагдсан бичил бизнес эрхлэгчид 1089 ажилтантай (зээл авахаас өмнөх ажилчдын тоо 661, нэмж авсан ажилчдын тоо 428) байна. Улаанбаатар хотын хувьд нийт 35-н бичил бизнес эрхлэгч 76-н ажлын байрыг бий болгосон байгаа бол орон нутгийн хувьд 158-н бизнес эрхлэгч 352 ажлын байрыг бий болгосон байна.

Хүснэгт 7. Эмэгтэй ажилчдын тоо, байршлаар

	Ажиглалт	Дундаж	Ст.Хазайлт	Минимум	Максимум
Улаанбаатар	46	2.1	2.0	0	9
Орон нутаг	149	2.1	2.3	0	15
Нийт	195	2.1	2.3	0	15

Нийт 1089 ажилчдын 404 нь буюу 37.1 хувь нь эмэгтэй ажилчид байна. Дунджаар нэг бичил бизнес эрхлэгч 2.1 эмэгтэй ажилтантай байна. Орон нутгийн хувьд 15 хүртэлх эмэгтэй ажилтантай үйл ажиллагаа эрхлэгч байгаа бол Улаанбаатар хотод 9 хүртэлх эмэгтэй ажилтантай байна.

Хүснэгт 8. Тайлбарлагч дамми хувьсагчид ажлын байр бий болгосон эсэхээр хэр ялгаатай байгааг харуулсан t тестүүд

Бүлгийн хувьсагчид	Ажлын байр бий болгосон эсэх		Р утга
	Тийм	Үгүй	
Зээл авсны дараах санхүүгийн үйлчилгээнд хамрагдсан	0.500	0.521	0.680
Бизнесийг гэр бүлийн гишүүнтэй хамтран эрхэлдэг	0.531	0.471	0.262
Зээлийн өмнөх сургалтад бүрэн хамрагдсан	0.535	0.463	0.181
Аж ахуй хөгжүүлэлтийн сургалтад хамрагдсан	0.646	0.463	0.002
Санхүүгийн бүртгэлийн сургалтад хамрагдсан	0.538	0.489	0.342
Маркетинг, борлуулалтын чиглэлийн сургалтад хамрагдсан	0.546	0.481	0.214
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалтын үйлчилгээ авсан	0.548	0.479	0.181
Бизнес, менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг авсан	0.539	0.486	0.304
Менторинг үйлчилгээ авсан	0.547	0.490	0.296
Төслийн хэрэгжилтэд ХАБ болон байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаар зөвлөгөө авсан	0.525	0.500	0.638
Эрэгтэй	0.485	0.529	0.401
Дээд боловсролтой	0.573	0.453	0.019
Улаанбаатарт амьдардаг	0.583	0.495	0.212
24 хүртэлх насны	0.500	0.510	0.943
25-34 насны	0.507	0.510	0.968
35-44 насны	0.614	0.456	0.004
45-54 насны	0.484	0.518	0.575
55-аас дээш насны	0.357	0.544	0.005

Дээрх хүснэгтэд тайлбарлагч дамми хувьсагчдын утга ажлын байр бий болгосон болон болгоогүй бүлгүүдээр хэр ялгаатай байгааг харуулсан t тестийн үр дүнг харууллаа. Аж ахуй хөгжүүлэлтийн сургалтад хамрагдсан эсэх, дээд боловсролтой эсэх болон 35-44 насны бүлэг гэсэн үзүүлэлтүүдийн t тестийн үр дүнгүүд статистикийн хувьд ач холбогдолтой байна. Тухайлбал, төслийн үр дүнд ажлын байр бий болгосон бүлгийн 64.6% нь аж ахуй хөгжүүлэлтийн сургалтад суусан бол ажлын байр бий болгоогүй гэсэн бүлгийн 46.3% нь уг

сургалтад суужээ. Мөн түүнчлэн, ажлын байр болгосон хүмүүсийн 57.3% нь дээд боловсролтой байгаа нь эсрэг бүлгээсээ 12 пунктээр өндөр байна.

Тэгшитгэл (1)-т харуулсан логит үнэлгээний үр дүнг Хүснэгт 9-т харууллаа. Аж ахуй хөгжүүлэлтийн сургалтад хамрагдсан, эргэлтийн хөрөнгө, 24 хүртэлх настай болон 35-44 настай гэсэн хувьсагчид 5 ба түүнээс доош хувийн түвшинд ач холбогдолтой байна. 55-аас доош насны бүлгийнхний ажлын байр бий болгох магадлал 55 ба түүнээс дээш насныхантай харьцуулахад насны бүлгээсээ хамаараад дунджаар 11.5 - 37 пунктээр илүү байна. Гэхдээ 24 хүртэлх настай болон 35-аас 44 насны бүлгийнхний маржинал нөлөө 5 ба түүнээс доош хувийн түвшинд ач холбогдолтой¹. 35-аас 44 настай оролцогчдын ажлын байр бий болгох магадлал нь 55 ба түүнээс дээш настай оролцогчидтой харьцуулахад дунджаар 28.1 пунктээр илүү байна. Мөн түүнчлэн, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан бүлгийн хувьд ажлын байр бий болгох магадлал нь хамрагдаагүй бүлгээсээ дунджаар 30.1 пунктээр илүү бөгөөд эргэлтийн хөрөнгө нэг сая төгрөгөөр өссөнөөр ажлын байр бий болгох магадлал дунджаар 0.6 хувиар нэмэгддэг байна.

Хүснэгт 9. Ажлын байр бий болгосон эсэхийг хамаарах хувьсагч болгон авч үзсэн логит үнэлгээний үр дүн

Тайлбарлагч хувьсагчид	Дундаж маржинал нөлөө	Ст.алдаа	P-утга
24 хүртэлх настай	0.370 *	0.184	0.045
25-34 насны	0.115	0.091	0.206
35-44 насны	0.281 ***	0.073	0.000
45-54 насны	0.154	0.080	0.053
Зээлийн өмнөх сургалтад бүрэн хамрагдсан	0.022	0.062	0.722
ХАБ, байгаль орчин, эрүүл мэндийн зөвлөгөө авсан	-0.111	0.085	0.191
Дээд боловсролтой	0.095	0.055	0.082
Бизнесийг гэр бүлийн гишүүнтэй хамтран эрхэлдэг	0.105	0.055	0.055
Эрэгтэй	-0.085	0.056	0.126
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалтын үйлчилгээ авсан	0.122	0.092	0.186
Аж ахуй хөгжүүлэлтийн сургалтад хамрагдсан	0.301 ***	0.068	0.000




¹ 24 хүртэлх настай оролцогчдын нийт түүвэрт эзлэх хувь маш бага буюу 4.2% байгаа учраас статистик хүч багатай бөгөөд үнэлгээ тийм ч найдвартай биш. Иймд энэ бүлгийн коэффициентийн утгыг нухацтай авч үзэж тайлбарлах шаардлагагүй.

Санхүүгийн бүртгэлийн сургалтад хамрагдсан	-0.114	0.094	0.224
Маркетинг, борлуулалтын чиглэлийн сургалтад хамрагдсан	0.041	0.097	0.673
Эргэлтийн хөрөнгө, сая.төг	0.006 *	0.003	0.023
Улаанбаатарт амьдардаг	0.150	0.088	0.087
Ажиглалтын тоо	312		
AUC	73.75		

Тэмдэглэл: Хүснэгт 2-т харуулсан тайлбарлагч хувьсагчдаас үндсэн хөрөнгө, санхүүгийн үйлчилгээнд хамрагдсан, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалтын үйлчилгээ болон бизнес, менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ авсан зэрэг хувьсагчдыг төгс соллиарити үүсгэж байсан тул үнэлгээнээс хассан. Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө гэсэн хувьсагчид VIF нь өндөр биш ч корреляцийн коэффициент өндөр бөгөөд үндсэн хөрөнгийг хоосон ажиглалт ихтэй учраас хассан. Зээлээс бусад үйлчилгээнүүдийн хувьд VIF нь 5-аас их байсан. Зээлээс бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагдсан эсэх гэсэн үзүүлэлтийн хувьд коэффициентын утга сөрөг гарсан тул үнэлгээнээс хассан.

Зураг 12-т статистикийн хувьд ач холбогдол бүхий хувьсагчдын магадлалын маржинал нөлөөг харууллаа. Аж ахуйн эрхлэлтийн сургалтад хамрагдсан оролцогчдын ажлын байр бий болгох магадлал 63.4% бол сургалтад хамрагдаагүй оролцогчдын хувьд 28.3% байна. Насны бүлгийн хувьд 35-аас 44 настай настай оролцогчдын ажлын байр бий болгох магадлал 69.3% байгаа нь 55 ба түүнээс дээш настай оролцогчидтой харьцуулахад 33 пунктээр илүү байна.

Зураг 12. Магадлалын маржинал нөлөө, ач холбогдол бүхий хувьсагчдын хувьд



Эргэлтийн хөрөнгө ба ажлын байр бий болох магадлалын хооронд эерэг хамааралтай боловч эргэлтийн хөрөнгийн утга өсөхийн хирээр ажлын байр бий болох магадлал нь саарч байна (**Зураг 12**). Тодруулбал, 1-ээс 25 сая хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд ажлын байр бий болгох магадлал нь 25 саяас их эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад илүү гэсэн үг.

5.2 Санхүүгийн байдал


Нийт судалгаанд оролцогчдын 98.7% нь зээл авсан бизнес, үйл ажиллагаагаа одоо эрхэлсээр байгаа гэж хариулсан байгаа бол 1.3 хувь нь буюу 5-н бичил бизнес эрхлэгч өөр чиглэлээр бизнес, үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд оролцогчдын ашиг орлого нь нэмэгдсэн бизнес эрхлэгчдийн дийлэнх буюу 20.0% нь 90-100 хувиар, 16.4% нь 41-50 хувиар, 13.9% нь 100-с дээш хувиар ашиг орлого нь тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Бизнес эрхлэгчдийн бизнес эрхэлсэн хугацаа /жилээр/

	Дундаж	Ст.Хазайлт	Максимум	Минимум
Бизнес эрхэлсэн хугацаа	10.2	8.8	49	0.3
Зээл авсан бизнесээ эрхэлсэн хугацаа	4.4	7.0	35	0.1

Бичил бизнес эрхлэгчид дунджаар 10.2 жил бизнес эрхэлсэн туршлагатай байна. Оролцогчдоос хамгийн ихдээ 49 жил, хамгийн багадаа 0.3 жил буюу 4 сар бизнес эрхэлсэн байна. Харин зээл авсан оролцогчид бизнес, үйл ажиллагаа эрхэлсэн туршлага дунджаар 4.4 жил байгаа бол хамгийн ихдээ 35 жил, хамгийн багадаа 0.1 жил буюу 1 сар бизнес эрхэлсэн ажлын туршлагатай байна.

Зураг 13. Гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран эрхэлдэг эсэх, байршлаар /хувь/



Судалгаанд оролцогчдын байршлаар нь авч үзэхэд Улаанбаатар хотод оршин суух оролцогчдын 63.3 хувь нь гэр бүлийн гишүүдтэйгээ буюу өрхийн бизнес эрхлэн удирдан явуулж байгаа бол орон нутагт бичил бизнес эрхлэгчдийн хувьд 63.6 хувь нь өрхийн гишүүдтэйгээ хамтран бизнес


эрхэлж байгаа юм. Байршлаар харьцуулан үзэхэд Улаанбаатар хотод болон орон нутагт бизнес эрхлэгчдийн хандлага ижил төстэй буюу дийлэнх хувь нь гэр бүлийн гишүүдтэй бизнес эрхлэх хандлагатай байна.

Зураг 14. Бизнесийн үйл ажиллагааны чиглэл /хувь/



Эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр нийт 11 салбарт үйл ажиллагаа эрхлэж байна. Үүнээс оролцогчдын 36.9 хувь нь боловсруулах үйлдвэрийн чиглэлээр харин бөөний болон жижиглэн худалдаа чиглэлээр 31.9 хувь нь, урлаг, үзвэр, тоглоом наадмын үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид хамгийн бага буюу 0.3 хувийг эзэлж байна.

Зураг 15. Бичил бизнес эрхлэгчдийн зээлийн зориулалт /хувь/



Бичил бизнес эрхлэгчдийн зээл авч буй зориулалтын хувьд эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зориулалтаар зээл авах нь 33.2 хувийг, үйл ажиллагаандаа хөрөнгө оруулах буюу тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар зээл авсан бизнес эрхлэгчид нь 31.6 хувийг эзэлж байна. Мөн үйл ажиллагааг өргөжүүлэх болон бараа материал түүхий эдийг нэмэгдүүлэх зориулалтаар зээл авч буй бизнес эрхлэгчид 8.6 хувийг бүрдүүлж байна.

Мөн зээлийн зориулалтад орон нутагт байршилтай бизнес эрхлэгчид нь мал аж ахуй болон хөдөө аж ахуйн зориулалтаар бизнесийн зээл авч байгаа онцлогтой бол Улаанбаатарт байршилтай бизнес эрхлэгчдийн хувьд бараа материал, түүхий эдийг нэмэгдүүлэх, ажлын байр завсарлах, томруулах зэргээр бичил бизнесийн зээл авах нь орон нутгийн бизнес эрхлэгчдээс өндөр хувьтай байгаа юм.

Хүснэгт 11. Бичил бизнес эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдсэн байдал, байршлаар /хувь/

№	Өсөлтийн хувь	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
1	10 хүртэлх хувь	2.2	1.3	1.5
2	11-20 хувь	4.4	4.0	4.1
3	21-30 хувь	10.9	2.7	4.6
4	31-40 хувь	2.2	8.7	7.2
5	41-50 хувь	21.7	14.8	16.4
6	51-60 хувь	2.2	4.7	4.1
7	61-70 хувь	6.5	4.0	4.6
8	71-80 хувь	0.0	4.0	3.1
9	81-90 хувь	2.2	0.7	1.0
10	90-100 хувь	21.7	19.5	20.0
11	100-с дээш хувь	13.0	14.1	13.9
12	Орлогогүй байснаас орлоготой болсон	0.0	3.4	2.6
13	Орлогогүй хэвээрээ байгаа	0.0	2.0	1.5
14	Орлого буурсан	6.5	4.7	5.1
15	Орлого өөрчлөгдөөгүй	6.5	11.4	10.3

Нийт судалгаанд оролцогчдын ашиг орлого нь 90-100 хувиар нэмэгдсэн 20.0%, 41-50 хувиар нэмэгдсэн нь 16.4%, 100-с дээш хувиар ашиг орлого нь нэмэгдсэн нь 13.9% нь байна. Байршлын хувьд Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн ашиг орлого өндөр хувиар өссөн нь 41-50 хувь байгаа бол орон нутагт 90-100% байна. Ашиг орлого нь нэмэгдсэн бизнес эрхлэгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал боловсруулах үйлдвэрлэл болон бөөний худалдаа болон жижиглэн худалдааны чиглэлд үйл ажиллагаа эрхлэгчид байна.

Хүснэгт 12. Тогтвортой байгаа эсэх /хувь/

Үзүүлэлт	Тийм	Үгүй
Эргэлтийн хөрөнгө	96.9	3.1
Үндсэн хөрөнгө	98.0	2.1


Үйлчлүүлэгч, хэрэглэгчийн тоо	96.4	3.6
Сарын орлого	93.9	6.2
Тоног төхөөрөмж	95.9	4.1
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	94.4	5.6

Бичил бизнес эрхлэгчдийн дэмжих хөтөлбөрт хамрагдсанаас хойш бизнесийн үйл ажиллагаа болон сарын орлого, үйлчлүүлэгчдийн тоо, бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэрэг дээр үзүүлэлтүүдийг тогтвортой байгаа эсэх талаар тодруулахад бүгд тогтвортой гэж хариулсан. Сарын орлогын хувьд бусад үзүүлэлтийг бодвол тогтворгүй байгаа шалтгааныг тодруулбал улирлын нөлөөлөл, үйл ажиллагаа нь орлогогүй болсон гэсэн хариултыг өгсөн байна.

5.3 Тулгарсан хүндрэл бэрхшээл


Арилжааны банк болон зээлийн шалгууртай холбоотой тулгарсан асуудлыг судалгаанд оролцогчдоос тодруулахад “Барьцаа хөрөнгийн шаардлага өндөр”, “Хугацаа их шаардсан”, “Бүрдүүлэх материал их” зэрэг асуудлаар хүндрэл бэрхшээл тулгардаг байна. Тус асуудлын хүрээнд доорх байдлаар үр дүнг тодруулсан.

Зураг 16. Зээлийн шалгууртай холбоотой гарсан хүндрэл бэрхшээл, байршлаар /хувь/




Зээл олгох шалгуурын хувьд судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 63.8% нь хүндрэл бэрхшээл гараагүй гэсэн байгаа бол 12.0% нь “Банкны шаардлага өндөр” гэж үзсэн, 11.7% нь “Барьцаа өндөр” гэж үзсэн байна. Байршлаар харвал Улаанбаатар хотын оролцогчдын хувьд барьцаа өндөр гэсэн бол орон нутгийн оролцогчдын хувьд банкны шаардлага өндөр гэж үзсэн байна.

Зураг 17. Арилжааны банкны зээлийн судалгаа чирэгдэлтэй байсан эсэх, байршлаар /хувь/




Арилжааны банкны зээлийн судалгаа чирэгдэлтэй байсан эсэх талаар байршлаар харвал Улаанбаатар хотын хувьд 65% нь, орон нутгийн хувьд 70.5% нь чирэгдэл ихтэй байна гэж үзсэн байна.

Зураг 18. Арилжааны банктai холбоотой тулгарсан асуудал, байршлаар /хувь/



Арилжааны банктai холбоотой тулгарсан асуудлыг байршлаар харвал нийт судалгаанд оролцогчдын 32.2% нь “Барьцаа хөрөнгийн шаардлага өндөр”, 20.0% нь “Хугацаа их шаардсан”, 19.1% нь “Бүрдүүлэх материал их” гэж үзсэн байна. Байршлын хувьд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэгчид “Бүрдүүлэх материал их”, орон нутгийн хувьд “Хугацаа их шаардсан” гэж үзэж байна.

Зураг 19. Эргэн төлөлттэй холбоотой асуудал үүссэн эсэх, байршлаар /хувь/



Зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудал үүссэн эсэх талаар торуулахад нийт судалгаанд оролцогчдын 97.1% -д нь асуудал үүсээгүй, 2.9% нь асуудал үүссэн гэж

хариулжээ. Тулгарсан асуудлыг тодруулахад хугацааг хоцроож төлсөн, улирлын чанартай бизнес эрхэлдэг, үйлчлүүлэгч хэрэглэгчийн тоо тогтвортой биш гэсэн байна.

Хүснэгт 13. Төсөлд хамрагдахын тулд бүрдүүлсэн баримт бичиг /хувь/

Хүндрэлтэй баримт бичиг		Хувь
1	Байхгүй	78.9
2	Банкны шалгуур өндөр	1.6
3	Барааны жагсаалт	1.6
4	Барьцаа хөрөнгө	8.3
5	Бүрдүүлэх бичиг баримт их байсан	4.1
6	Газрын гэрчилгээ	1.6
7	Зээлийн мэдээлэл бүрдүүлэх	1.6
8	НДШ заавал төлөх ёстой шаардлага	0.5
9	Төсөл бичих	1.6
10	Хүнд суртал ихтэй	0.5
Шаардлагагүй баримт бичиг		
1	Байхгүй	84.0
2	Банкны шаардлага өндөр	2.1
3	Барааны жагсаалт	1.0
4	Барьцаа хөрөнгө	4.1
5	Бусад салбарын баримт бичгийг шаарддаг	0.5
6	Зээлийн мэдээлэл бүрдүүлэх	1.0
7	И-Монголиа лавлагаа	3.1
8	Нөхрийн бичиг баримт шаардлагагүй байсан	0.5
9	Улсын бүртгэлийн мэдээлэл, багын даргын тодорхойлолт	0.5
10	Хуулбар баримт бичиг	0.5
11	Цахимаас авах боломжтой мэдээллийг заавал цаасаар авдаг	0.5
12	Ажилд авах хүний РД нэхсэн	0.5
13	Хэт олон материал бүрдүүлэх авчруулах өөрсдөө татаад авах зүйлийг хүртэл шаардах	0.5
14	Шүүхийн тодорхойлолт	1.0

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь хүндрэлтэй болон шаардлагагүй баримт бичиг байхгүй гэж үзсэн байна. Харин хүндрэлтэй бичиг баримт бичиг болон шаардлагагүй баримт бичгийн хувьд мөн ялгаагүй барьцаа хөрөнгө орсон байна.

БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

6.1 Дүгнэлт

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн судалгааны мэдээлэлд үндэслэн ажлын байр бий болгох магадлалыг оролцогчийн нас, хүйс, боловсрол зэрэг нийгэм, эдийн засгийн шинж чанар, бизнесийн эргэлтийн хөрөнгө болон төслийн зээлээс бусад төрлийн сургалт, үйлчилгээнд хамрагдсан байдал зэргээс хамааруулан логит үнэлгээ хийлээ. Хэдийгээр нийт ажиглалтын тоо 379 боловч регрессийн шинжилгээний үр дүнг гажуудуулах нөлөө бүхий сондгойрогч ажиглалтуудыг хассанаар нийт 312 ажиглалтын хувьд үнэлгээг хийсэн.

Логит үнэлгээний үр дүнд аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан, хөдөлмөрийн идэвхтэй насны бүлэг буюу 35-аас 44 насны иргэд болон бага эргэлтийн хөрөнгөтэй бизнесүүд ажлын байрыг хамгийн их бий болгодог гэдэг нь харагдлаа. Иймд төсөлд хамрагдагсдыг аж ахуй эрхлэлтийн болон бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамруулах нь төслийн үр дүнд ажлын байр бий болох магадлалыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Мөн түүнчлэн, бага эргэлтийн хөрөнгөтэй бизнесүүдэд эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зээл олгосноор ажлын байр бий болгох магадлалыг нэмэгдүүлэх боломжтой юм. Эргэлтийн хөрөнгө өндөр бизнесүүдийн хувьд ажлын байрны тоо нэмэгдүүлэх гэхээсээ илүүтэй технологи хөгжүүлэх, чанартай ажлын байр бий болгох зэрэгт чиглэсэн үр дүн илүү чухал байж болох юм. Тухайлбал, эргэлтийн хөрөнгө 25 сая хүртэлх бол төслийн үр дүнг зөвхөн ажлын байр бий болгосноор тодорхойлж, харин 25 саяас дээш эргэлтийн хөрөнгөтэй бол технологи хөгжүүлсэн, ур чадвартай, албан ажлын байр бий болгосноор төслийн үр дүнг хэмжиж болох юм.

6.2 Зөвлөмж

Судалгааны үр дүн нь төсөлд хамрагдагсдыг аж ахуй эрхлэлтийн болон бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамруулах, мөн олгогдсон бичил зээл нь оролцогчдын эргэлтийн хөрөнгө болон үйл ажиллагааны хэрэгцээнд худалдан авсан тоног төхөөрөмж нь зэрэг үр дүнтэй зарцуулагдсан нь ажлын байр бий болгох магадлалд нөлөө үзүүлж байгааг судалгааны үр дүн харуулж байна. Иймд доорх асуудлын хүрээнд арга хэмжээ авч хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Төслийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн болон бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамруулах, сургалтын чанарыг сайжруулах;
- Эргэлтийн хөрөнгө бага үйл ажиллагаа эрхлэгчдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Үйл ажиллагааны цар хүрээг зээл олгох болон бусад шалгуурт харгалзан үздэг байх;
- Хөтөлбөрт хамрагдсан бичил бизнес эрхлэгчидтэй эргэх холбоотой үйл ажиллагаа явуулах;
- Хөтөлбөр арга хэмжээний үр дүнг хэмжигдэхүйц үзүүлэлтээр хянах.

Эдгээр асуудлыг хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ анхаарч шаардлагатай бол бодлогын баримт бичигт тусгах нь бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.